



МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
И-мэйл: comcor@iaac.mn, Вэб сайт: http://iaac.mn

2022.06.30 № 05/9057
танай _____-ны № 2/7240-Т.

НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ
АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Г.ЭНХТАЙВАН ТАНАА

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан
мэдүүлэг хянасан тухай

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын Хууль эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтнээр томилогдохоор нэр дэвшсэн Батбаярын Оюун-Эрдэнэ, Мэдээллийн технологийн хэлтсийн мэдээллийн технологи хариуцсан ахлах мэргэжилтнээр томилогдохоор нэр дэвшсэн Адилбишийн Энхжаргал нарын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянахад тухайн албан тушаалд томилоход ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Нэр дэвшигч нар нь тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөл байдалд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж байх, мөн хуулийн 19, 20 дугаар зүйлд заасан давхар ажил эрхлэхтэй холбогдсон хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй.

Түүнчлэн Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-т заасан хугацаанд хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргахыг анхаарна уу.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ОРЛОГЧ
БӨГӨӨД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЛБАНЫ
ДАРГА, АХЛАХ КОМИССАР



Л.СҮХ-ОЧИР

1422003013313